УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/61/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Авирмэд<br>Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.5.1 Төсвийн төлөвлөлт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

3.5.3 Нэмэлт төсөв

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАРУУНТУРУУН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АНХБАЯР ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № ОВА-2026/61/НА-СТА-Т1113
танай_______________-ны №__________________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050269

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **180,040,435.50** | **52,832,376.50** |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 180,040,435.50 | 20,832,376.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 168,098,559.00 | 8,890,500.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 973,000.00 | 36,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,640,559.00 | 8,854,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 133,485,000.00 | - |
| 35600 | Мал амьтад | 11,941,876.50 | 11,941,876.50 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | 32,000,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | - | 32,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,313,970,421.73** | **2,408,995,999.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,313,970,421.73 | 2,408,995,999.18 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,127,116,121.69 | 2,191,640,199.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 892,260,817.66 | 875,557,158.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (443,204,233.49) | (430,373,097.55) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 388,706,773.00 | 377,377,273.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (196,937,369.29) | (237,141,694.85) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 389,771,972.40 | 444,810,934.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (324,590,408.45) | (344,693,372.94) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,088,146.77 | 53,088,146.77 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,588,809.45) | (35,265,813.57) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,475,867,449.00 | 1,441,828,792.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (244,957,643.28) | (212,846,423.59) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 448,302,660.25 | 549,404,460.25 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (281,603,233.43) | (290,106,162.76) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 186,854,300.04 | 217,355,800.03 |
| 39301 | Програм хангамж | 1,130,000.00 | 3,330,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,113,499.96) | (779,999.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 187,662,800.00 | 216,882,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (825,000.00) | (2,077,000.01) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,494,010,857.23** | **2,461,828,375.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,802,800.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,802,800.00 |
| **413** | **Өглөг** | - | 1,802,800.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 162,800.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,640,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,640,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,494,010,857.23** | **2,460,025,575.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,494,010,857.23 | 2,460,025,575.68 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,730,283,204.51 | 1,737,929,774.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,730,283,204.51 | 1,766,498,389.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (28,568,614.70) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 320,240,420.37 | 278,608,568.93 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,494,010,857.23** | **2,461,828,375.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,026,238,964.00** | **1,308,752,516.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **273,047,161.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 273,047,161.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 273,047,161.93 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 273,047,161.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,026,238,964.00** | **1,035,705,355.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74,247,564.00 | 4,388,355.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,369,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,000,100.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,878,464.00 | 2,388,355.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 951,991,400.00 | 1,031,317,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 951,991,400.00 | 1,031,317,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,446,319,172.85** | **1,175,326,556.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,446,319,172.85** | **1,175,326,556.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,402,218,382.99 | 1,153,251,397.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 626,898,809.46 | 711,080,267.54 |
| 210101 | Үндсэн цалин | 340,265,878.05 | 410,301,180.69 |
| 210102 | Нэмэгдэл | 231,474,645.78 | 270,187,886.85 |
| 210104 | Урамшуулал | 18,975,600.00 | 12,375,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 36,182,685.63 | 18,216,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,709,391.88 | 88,753,126.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,642,069.19 | 60,481,829.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,302,918.15 | 7,115,509.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,204,259.07 | 3,594,714.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,112,029.10 | 3,512,214.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,448,116.37 | 14,048,858.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,488,512.40 | 38,807,522.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,238,913.40 | 12,480,172.41 |
| 210302 | Түлш, халаалт | 28,249,599.00 | 26,327,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 67,764,564.40 | 31,455,239.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,126,000.00 | 1,897,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,817,109.00 | 24,903,138.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,743,855.40 | 1,958,701.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 827,600.00 | 1,496,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,147,500.00 | 2,616,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 295,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 7,852,500.00 | 2,616,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,052,844.00 | 4,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,052,844.00 | 4,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,186,814.00 | 4,469,624.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,843,000.00 | 66,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 252,450.00 | 392,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 678,592.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 230,000.00 | 198,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,208,164.00 | 1,931,792.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 566,969,946.85 | 271,249,618.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 201,383,448.50 | 49,160,067.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,071,500.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 363,514,998.35 | 221,589,551.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,100,789.86 | 22,075,158.73 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,701,408.00 | 8,420,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 42,401,408.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,300,000.00 | 500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 399,381.86 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 399,381.86 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 13,655,158.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 13,655,158.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(420,080,208.85)** | **133,425,960.90** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 161,994,575.60 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 161,994,575.60 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (161,994,575.60) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(420,080,208.85)** | **(28,568,614.70)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,026,238,964.00** | **1,035,705,355.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,026,238,964.00** | **1,035,705,355.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74,247,564.00 | 4,388,355.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 19,369,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,000,100.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,878,464.00 | 2,388,355.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 951,991,400.00 | 1,031,317,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 951,991,400.00 | 1,031,317,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,014,358,964.00** | **954,539,205.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,014,358,964.00** | **954,539,205.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **970,739,582.14** | **932,464,046.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 627,248,556.34 | 711,080,267.54 |
| 210101 | Үндсэн цалин | 341,024,135.35 | 410,301,180.69 |
| 210102 | Нэмэгдэл | 231,180,577.54 | 270,187,886.85 |
| 210104 | Урамшуулал | 18,975,600.00 | 12,375,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 36,068,243.45 | 18,216,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,427,765.00 | 88,753,126.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,322,131.08 | 60,481,829.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,268,800.00 | 7,115,509.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,164,633.92 | 3,594,714.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,134,500.00 | 3,512,214.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,537,700.00 | 14,048,858.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,488,512.40 | 38,807,522.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,238,913.40 | 12,480,172.41 |
| 210302 | Түлш, халаалт | 28,249,599.00 | 26,327,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,482,934.40 | 24,075,701.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,032,000.00 | 1,853,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,090,079.00 | 17,692,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,743,855.40 | 1,833,601.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,117,000.00 | 1,496,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,242,500.00 | 976,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 420,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,822,500.00 | 976,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,124,000.00 | 4,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,124,000.00 | 4,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,393,814.00 | 5,074,624.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,050,000.00 | 671,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 399,270.00 | 392,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 386,767.00 | 678,592.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 130,000.00 | 198,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,824,577.00 | 1,931,792.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 166,331,500.00 | 58,876,805.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 164,284,000.00 | 58,376,805.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,047,500.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,619,381.86** | **22,075,158.73** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,220,000.00 | 8,420,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 40,920,000.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,300,000.00 | 500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 399,381.86 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 399,381.86 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 13,655,158.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 13,655,158.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **11,880,000.00** | **81,166,150.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **81,166,150.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **81,166,150.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 81,166,150.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 81,166,150.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(81,166,150.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 11,880,000.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 443,487,232.35 | 320,240,420.37 | 1,730,283,204.51 | 2,494,010,857.23 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **443,487,232.35** | **320,240,420.37** | **1,730,283,204.51** | 2,494,010,857.23 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **443,487,232.35** | **320,240,420.37** | **1,730,283,204.51** | 2,494,010,857.23 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **443,487,232.35** | **320,240,420.37** | **1,730,283,204.51** | 2,494,010,857.23 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 36,215,184.59 | 36,215,184.59 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **443,487,232.35** | **320,240,420.37** | **1,766,498,389.10** | 2,530,226,041.82 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (41,631,851.44) | - | (41,631,851.44) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (28,568,614.70) | (28,568,614.70) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 443,487,232.35 | 278,608,568.93 | **1,737,929,774.40** | 2,460,025,575.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,031,317,000.00 | 1,017,661,841.27 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,031,317,000.00 | 1,017,661,841.27 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,021,897,000.00 | 1,009,241,841.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 719,501,400.00 | 711,080,267.54 |
| 210101 | Үндсэн цалин | 701,285,400.00 | 410,301,180.69 |
| 210102 | Нэмэгдэл | - | 270,187,886.85 |
| 210104 | Урамшуулал | - | 12,375,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,216,000.00 | 18,216,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,791,100.00 | 88,753,126.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,074,300.00 | 60,481,829.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,179,200.00 | 7,115,509.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,589,500.00 | 3,594,714.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,589,500.00 | 3,512,214.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,358,600.00 | 14,048,858.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,074,000.00 | 38,807,522.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,746,600.00 | 12,480,172.41 |
| 210302 | Түлш, халаалт | 26,327,400.00 | 26,327,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,605,100.00 | 24,075,701.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,212,700.00 | 1,853,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,692,400.00 | 17,692,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,000,000.00 | 1,833,601.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 1,496,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,908,600.00 | 62,908,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,850,000.00 | 17,850,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,058,600.00 | 45,058,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,915,600.00 | 4,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,915,600.00 | 4,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,176,200.00 | 8,074,624.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 675,000.00 | 671,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 392,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 700,000.00 | 678,592.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 198,000.00 | 198,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,800,000.00 | 3,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,000,000.00 | 1,931,792.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 71,925,000.00 | 70,722,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,425,000.00 | 70,222,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,420,000.00 | 8,420,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,420,000.00 | 8,420,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,920,000.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,031,317,000.00 | 1,017,661,841.27 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,031,317,000.00 | 1,017,661,841.27 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,031,317,000.00 | 1,017,661,841.27 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 19 | 18 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 10 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,388,355.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,388,355.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,388,355.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,388,355.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,388,355.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,388,355.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,388,355.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,388,355.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар нь орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд -2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын тайлант оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,182.4 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 180,040.4 | 52,832.4 | -127,208.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,313,970.4 | 2,408,996.0 | 95,025.6 |
| **Нийт хөрөнгө** | **2,494,010.9** | **2,461,828.4** | **-32,182.5** |
| Өр төлбөр | 0.0 | 1,802.8 | 1,802.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,494,010.9 | 2,460,025.6 | -33,985.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,494,010.9** | **2,461,828.4** | **-32,182.5** |

Бараа материалын дансны үлдэгдэл 52,832.4 мянган төгрөг болж 127,208.0 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, аж ахуй, бусад хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,408,996.0 мянган төгрөг болж 95,025.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хүлээн авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд авлага үүсээгүй ба шуудан холбоо интернэтийн өр 162.8 мянга, автомашин засварын 1,640.0 мянга төгрөг нийт 1,802.8 мянган төгрөгийн өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,460,025.6 мянган төгрөг болж 33,985.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,025,736.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг 5,580.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,031,317.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,031,317.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,017,661.8 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 13,655.1 мянган төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага<br>80101- Үндсэн үйл ажиллагааны зардал | 684,589.8 | 675,523.3 | 8,787.1 | 98.7 |
| 2 | 80106- Баг, хорооны зардал | 170,168.3 | 169,199.5 | 838.7 | 99.4 |
| 3 | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 70,462.6 | 69,215.2 | 1,247.3 | 98.2 |
| 4 | 80112- Нийтлэг үйлчилгээ | 24,051.2 | 23,881.8 | 1,778.9 | 99.0 |
| 5 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 9,420.0 | 8,420.0 | 1,000.0 | 89.3 |
| 6 | 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө | 31,000.0 | 31,000.0 | 0.0 | 100.0 |
| 7 | 81507- Мал тооллого | 1,200.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 8 | 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол | 1,200.0 | 1,200.0 | 0.0 | 100.0 |
| 9 | 82801- Улсын их баяр наадам | 5,000.0 | 5,000.0 | 0.0 | 100.0 |
| 10 | 71413- Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх<br>81701- Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх | 33,025.0 | 33,022.0 | 2.0 | 99.9 |
| 11 | 72208- Ахмад настны хөгжил хамгаалал<br>81549- Ахмадын сан | 1,200.0 | 1,200.0 | 0.0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөцөөс 2,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,388.3 мянган төгрөг, нийт 4,388.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.
Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Программ хангамжтай холбоотой гарсан зардал | 3,000.0 | Си ти эс санхүүгийн программ |
| 2 | Унаа хоолны зардлын гүйцэтгэл | 0.0 | Байхгүй |
| 3 | Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал | 0.0 | Байхгүй |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал | 0.0 | Байхгүй |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 0.0 | Байхгүй |
| 6 | Байгууллагын орон тоо | 18 | 2025 онд нийгмийн ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ба оронд ажилтан аваагүй |
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл | 0.0 | Байхгүй |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Засаг даргын тамгын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засаг даргын тамгын газар нь тайлант онд багийн Засаг дарга нарын өрөөний хэсэгчилсэн засварын ажил, конторын барилгын цонх солих ажлыг нийт 45,058.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 2/17 дугаар албан бичгээр ирүүлсэн.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,446,319.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,463.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,570.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,175,326.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,753.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,402.6 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161, хугацаа хоцроосон 8, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1-т “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д

заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2-т "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна" гэж заасан байхад Сангийн яамнаас чиглэл өгч төсвийн байгууллагуудын картыг дансыг хаалгаснаас шалтгаалан төсвөөс байгууллагын нярвын дансаар дамжуулан бэлэн мөнгө гарган зарцуулж байгаад зөвлөмж өглөө.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц, орон тоонд байхгүй багийн сахиул-2, сантехникч-1, олон нийтийн байцаагч-1, нийт 4 гэрээт ажилтан ажиллуулсан асуудлыг дараачийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,861.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***1.1. <u>Илрүүлэлт:</u>***

Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар нярвын дансаар дамжуулан 23,861.2 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан байна.

***<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>***

Цаашид байгууллагын нярвын хувийн дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэзс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Нярвын дансаар бэлэн мөнгө дамжуулсан | 1 | 23,861.2 | | | | | 1 | 23,861.2 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 23,861.2 | | | | | 1 | 23,861.2 |
| **Нийт дүн** | **1** | **23,861.2** | | | | | **1** | **23,861.2** |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр